



130

ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/55

Баян-Өндөр сум


Мөнгөн дэмжлэг үзүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/524, А/525 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхий, тив, олон улс, биеийн тамир, спортын салбарын тэмцээнд оролцох тамирчдад зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мөнгөн дэмжлэгт зарцуулагдах 10,364,000 (арван сая гурван зуун жаран дөрөв) төгрөгийг зохих журмын дагуу нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.ДЭЛГЭРБАЯР

131

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн
А/55 дугаар тушаалын хавсралт

**ТЭМЦЭЭН, УРАЛДААНЫ МӨНГӨН ДЭМЖЛЭГТ ЗАРЦУУЛАГДАХ
ТӨСВИЙН ТООЦОО**

№	Шийдвэрийн нэр, дугаар, огноо	Спортын төрөл	Зардлын нэр	Хүний тоо		Нэг бүрийн үнэ	Бүгд дүн (төгрөгөөр)
				Тамирчин	Дасгалжулагч		
1	2	3	4	5	6	7	8
1.	Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/524 дугаар захирамж	Узбекистан улсын Ташкент хотод 2025 оны 06 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулагдах хөнгөн атлетикийн олон улсын тэмцээн	Замын зардал	1	-	500,000	500,000
2.		Бүгд Найрамдах Польш Улсад зохион байгуулагдах чөлөөт бөхийн олон улсын тэмцээнд	Замын зардал		1	500,000	500,000
3.		БНХАУ-ын Хонг Конг Улсад зохион байгуулагдах чөлөөт бөхийн олон улсын тэмцээн	Замын зардал	3		500,000	1,500,000
4.		Тайландын Хаант Улсад зохион байгуулагдах бадминтоны ахмадын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн	Замын зардал	3		1,000,000	3,000,000
		Дүн					5,500,000

5.	Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/525 дугаар захирамж	Хөвсгөл аймагт зохион байгуулагдах Биеийн тамир, спортын салбарын тэмцээн	Замын зардал	4 машин	80л	2,700	864,000
			Хоолны зардал	20	5 өд	30,000	3,000,000
			Оролцоо-ны төлбөр				1,000,000
		Дүн					4,864,000
	Төсвийн нийт дүн						10,364,000

---oOo---



